



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 13 өдөр

Дугаар А/261

Номгон


Эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр авч
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "б", 29.1.6-ын "в", 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2021 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 05/А/12 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын 2020 оны 37 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус аймгаар улсын чанартай автозам дайран өнгөрдөг, уул уурхайн үйлдвэрлэл их, жижиг дунд үйлдвэрлэл хөгжсөн шалтгаанаар иргэдийн хөдөлгөөн, тээврийн хэрэгслийн цуваа тасрахгүй байгаа нь аймгийн хэмжээнд коронавирусын халдвар тархах эрсдэл "Маш өндөр" гэсэн дүгнэлтийг мэргэжлийн байгууллагууд гаргасан тул үүсч болзошгүй эрсдэлтэй нөхцөл байдлаас урьдчилан сэргийлж, сорил, шинжилгээний нөөцийг бүрдүүлэх зорилгоор эрүүл мэнд, зорилтот бүлэг, буян ном, хойшлуулшгүй албан томилолтоос бусад тохиолдолд полимерагийн гинжин урвал (ПГУ) болон түргэвчилсэн тестийн шинжилгээг төлбөртэй болгож, сорьц шинжилгээ авах зориулалтын цэгийг холбогдох дүрэм, журмын дагуу байгуулахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал)-д үүрэг болгосугай.

2. Коронавируст халдвар илрүүлэх төлбөртэй шинжилгээг өөрийн хүсэлт гаргасан болон дэглэм зөрчсөн иргэн, байгууллага, мөн ашгийн үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагаас авах бөгөөд шинжилгээ хийх, үнэ тогтоох, орлогыг зарцуулах журмыг хавсралтаар баталсугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн бодлогын асуудал хариуцсан Орлогч, Онцгой комиссын гишүүн (Г.Энхбаяр)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

• 621010651

Аймгийн Засаг даргын 2021 оны 04
дүгээр сарын 13-ны өдрийн А/261
дүгээр захирамжийн хавсралт

КОРОНАВИРУСЫН ХАЛДВАР ИЛРҮҮЛЭХ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮНЭ ТОГТООХ, ОРЛОГЫГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

Нэг.Зорилго

1.1. Аймгийн хэмжээнд коронавирусын халдвартай тэмцэх бэлтгэл, бэлэн байдлыг хангах, коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, халдвар тархах эрсдэлээс хамгаалах, шинжилгээ авах сорьц, тестийн нөөцийг бүрдүүлэх оршино.

Хоёр. Төлбөрийн ангилал

2.1. Дараах тохиолдолд төлбөр авахгүй.

2.1.1. 16 хүртэлх насны хүүхэд,

2.1.2. Жирэмсэн эмэгтэй,

2.1.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн,

2.1.4. 60 дээш ахмад настан, хорт хавдартай иргэн,

2.1.5. Тархвар зүйн заалттай дам болон ойрын хавьтал,

2.1.6. Онцгой нөхцөл ажиллаж байгаа алба хаагч (Онцгой байдал, Цагдаа, Тагнуул, Эрүүл мэнд, Мэргэжлийн хяналт),

2.1.7. Албан томилолтоор явж байгаа төрийн албан хаагчид.

2.2. Дараах тохиолдолд төлбөр авна.

2.2.1. Иргэн өөрийн хүсэлтээр (орон нутгийн орох гарах хөдөлгөөн оролцох),

2.2.2. Тээврийн жолооч (орон нутгийн болон хот хоорондын хөдөлгөөнд оролцох),

2.2.3. Аж ахуйн нэгж байгууллага ажилтан, алба хаагчдаа шинжилгээнд хамруулах хүсэлт гаргасан бол,

2.2.4. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм зөрчсөн иргэн,

2.2.5. Уул уурхайн салбар,

2.2.6. Гадаадын харьяат иргэд.

Гурав. Шинжилгээний жишиг үнэ

3.1. Антиген илрүүлэх эсвэл IgM, IgG эсрэг бие илрүүлэх түргэвчилсэн тестийн шинжилгээний жишиг үнэ 25.000 (хорин таван мянга) төгрөг,

3.2. Урвуу транскриптазат-полимеразийн гинжин урвал (УТ-ПГУ) шинжилгээний жишиг үнэ 82.000 (наян хоёр мянга) төгрөг,

3.2. Урвуу транскриптазат-полимеразийн гинжин урвал (УТ-ПГУ) шинжилгээний жишиг үнэ 82.000 (наян хоёр мянга) төгрөг,

-(Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05/А/12 дугаар тушаалаар хамтран баталсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх, жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах заавар” 2 дүгээр хэсгийн 2.2.1, 2.2.2 дах заалтыг үндэслэв).

Дөрөв. Шинжилгээ авах байршил

4.1. Антиген илрүүлэх эсвэл IgM, IgG эсрэг бие илрүүлэх түргэвчилсэн тестийн шинжилгээний 1 дүгээр цэг-Өлзийтийн авто тээврийн шалган бүртгэх товчооны Эрүүл мэндийн лаборатори,

4.2. Антиген илрүүлэх эсвэл IgM, IgG эсрэг бие илрүүлэх түргэвчилсэн тестийн шинжилгээний 2 дугаар цэг-Татварын (хуучин) байр,

4.3. Урвуу транскриптазат-полимеразийн гинжин урвал (УТ-ПГУ) шинжилгээний 1 дүгээр цэг-Татварын (хуучин) байр,

4.4. Эрүүл мэндийн Шуурхай штабын 70440006 тусгай дугаарт холбогдож бүртгүүлэн Нэгдсэн эмнэлгийн хөдөлгөөнт явуулын лаборатори урвуу транскриптазат-полимеразийн гинжин урвал (УТ-ПГУ) шинжилгээ болон антиген илрүүлэх эсвэл IgM, IgG эсрэг бие илрүүлэх түргэвчилсэн тестийн шинжилгээг дуудлагаар хийнэ.

4.5. Төлбөрт үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэд төлбөрийн баримт, иргэний үнэмлэх, байгууллагын үнэмлэхийн хамт ойролцоох цэгт ирж, халдвар хамгааллын дэглэм баримтлан үйлчилгээ авна.

4.6. Төлбөргүй үйлчилгээ авах иргэд энэ журмын 2 дугаар хэсгийн 2.1-т заасан шалтгааны нотлох баримтыг хавсарган, иргэний үнэмлэхтэй ойролцоох цэгт ирж, халдвар хамгааллын дэглэм баримтлан үйлчилгээ авна.

Тав. Орлого төвлөрүүлэх, зарцуулах

5.1. Төлбөрт үйлчилгээ авч байгаа иргэд, хуулийн этгээд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагууд ПГУ болон түргэвчилсэн сорил өгөхдөө төлбөрийг бэлэн болон бэлэн бусаар хийж болно. Төлбөрийг бэлэн бусаар хийх тохиолдолд аймгийн **Нэгдсэн эмнэлгийн нэмэлт санхүүжилтийн Төрийн сангийн 100030020402 (Дансны нэр: БХ.Нэгдсэн эмнэлэг н.с) тоот дансаар** гүйлгээний утга дээр нь: овог нэр, регистрийн дугаар, утасны дугаарыг тэмдэглэж, тухайн шинжилгээний төлбөрийг шилжүүлнэ.

5.2. Төвлөрсөн орлогыг Монгол Улсын Шадар сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 05/А/12 дугаар тушаалаар хамтран баталсан “Коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх шинжилгээг төлбөртэй хийх, жишиг үнэ тогтоох, орлогыг зарцуулах заавар”-ын 3, 4 дүгээр хэсэгт заасан үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулна.

Зургаа. Хяналт хариуцлага

6.1. Төлбөртэй шинжилгээний орлого, зарцуулалтын тайланг тухай бүр нь байгууллагын шилэн дансанд ил тод, нээлттэй мэдээлэх бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс хяналт тавьж ажиллана.

6.2. Энэ журмыг зөрчсөн иргэн хуулийн этгээдийг хуулийн байгууллагад шилжүүлж, хариуцлагын арга хэмжээ тооцно.

-----oO-----